

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛ

О.Мөнхбат

МУИС-ийн профессор

(<https://orcid.org/0000-0002-7869-9144>),

В.Алтансүх

МУИС-ийн улс төр судлалын докторант

Abstract: *In this paper, the authors considered on political party's full membership in Mongolia and analyzed its consequences for whole society. According to Supreme court of Mongolia, 667.529 thousand citizens are members of various political parties which consists 20.2 percent of total population of the country. The authors explained a main reasons or motivations of political party membership from point of view of such social theories as theory of identity, Attachment theory and theory of conspiracy.*

In the paper, the authors used qualitative and quantitative data from various researches done by several research organizations like social research institute of National university of Mongolia (NUM) and department of political science, NUM. According to the authors, despite party membership is one of important human rights, it become deviant social phenomena used by nomenclature of political parties for election meddling that posed a real threat for democracy in the country.

At the end, the authors concluded that a party membership must be banned and parties should become political institution with limited policy nomenclature.

1. Оршлын оронд:

Монгол улсын Үндсэн хуульд “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.....Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно” (Монгол улсын Үндсэн хууль, 2022) гэж заажээ.

Монгол улсын иргэд 36 гаруй улстөрийн нам эвсэлд нэгдэж, эл эрхээ эдэлдэг бөгөөд зөвхөн хуульд (Төрийн албаны тухай хууль, 2022) заасан зарим албан тушаал бүхий иргэдийг улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэхийг шаарддаг. Нам эвсэлд эвлэлдэн нэгдэх нь ийнхүү хүний эрхийн асуудал мэт боловч өнөөгийн нөхцөл байдалд гишүүнчлэл нь бусад иргэдийн эрхийг зөрчих нэг арга хэрэгсэл болсон нь сэтгэл түгшээж байна. Нийт иргэдийн дунд улстөрийн нам эвсэлд итгэх итгэл буурч, эрх баригч болон сөрөг хүчний нам эвслүүд авлига, хээл хахуулийн тогтолцооны голлох хөдөлгөгч хүч болсныг судалгаа шинжилгээний дүн харуулж байна. МУИС-ийн судалгааны баг болон УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороотой (УИХ, 2014) хамтран хийсэн судалгааны дүнгээс харах өндөр түвшний авлига үндэсний аюулгүй байдалд зарим талаар болон, сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн гэж иргэдийн 92.4% нь үзээд улс төрийн нам энэ авлигын гол субъект болсон гэдэгтэй санал нэгджээ.

Максима консалтинг ХХК-аас Авлигатай тэмцэх газрын захиалгаар “Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа 2019”-гаар авлига тархсан байдлаар засгийн газар (яам, агентлаг)-ын дараа хоёрдугаарт жагсаж байна.

2020 оны 1 дүгээр сарын байдлаар 3,296,866 (ҮСХ, 2021) иргэнтэй байсан Монголын улсын 667,529 иргэн аль нэг намын гишүүнчлэлтэй аж. Дээд шүүхийн мэдээлснээр Монгол улсад нийт 36 улс төрийн нам бүртгэлтэй бөгөөд эдгээр намуудад 667,529 мянган хүн гишүүнээр бүртгүүлжээ (Дээд шүүх, 2021). УИХ-д суудалтай намуудын гишүүдийг тоолбол, МАН 161,300 гишүүн, АН 150,000, МАХН 35000 мянган гишүүнтэй бол ХҮН 1024 гишүүнтэй хэмээн мэдүүлсэн байна.

Чухамдаа нийт хүн амын 20,2 хувь намын гишүүн байгаа нь дэлхийд толгой цохих бөгөөд ганц эрх барих намтай, дэлхийн хамгийн олон хүн амтай БНХАУ-ыг бол бүр ардаа холоо хаяжээ. Хятадын коммунист нам (ХКН) 2020 оны 10 дугаар сарын байдлаар 91,91 сая гишүүнтэй байсан нь нийт хүн амын 6,6 хувьтай тэнцэх аж (Statista, 2021).

2. Судлагдсан байдлын товч тойм

Улс төрийн нам Монголын судлаачдын судалгааны нэг чухал талбар байсаар ирэв. 1990 -ээд оноос өмнөх судалгаа голлон нэг намын тогтолцоог зөвтгөх, намын хошуучлан манлайлах үүрэг зэрэг үзэл суртлын шинжтэй асуудалд төвлөрч байсан бол 1990 оноос хойш намыг улстөрийн тогтолцооны нэг чухал институци, улс төрийн олон ургальч үзэл баримтлал, ардчилалын шалгуур болох талаас нь илүүтэй судалж байна.

Ялангуяа улс төрийн намын үүрэг, авлига, төлөвшил, санхүүжилтын ил тод байдлын талаарх судалгаа зонхилох хандлагатай байгаа бөгөөд намын хатуу гишүүнчлэлийн асуудал ч анхаарлын төвд байна.

С.Мөнхбат (С.Мөнхбат, 2009), Д.Бадамдаш (бусад, 2020), Б.Эрдэнэдалай (Б.Эрдэнэдалай, 2021/3) О.Мөнхбат (О.Мөнхбат, 2019) зэрэг судлаачид намын төлөвшил болон улстөрийн авлигын асуудлыг авч судалсан бөгөөд Монголын улс төрийн намуудын хөгжил, тулгарч буй хүндрэл бэрхшээл, улс төрийн хүрээний авлига, хууль бус нөлөөлөл, шалтгаан үр дагаварт анхаарлаа хандуулжээ.

Ц.Мөнхцэцэг (Ц.Мөнхцэцэг, 2018) нарын судлаачид намын санхүүжилт, дэлхийн улс орнуудын улс төрийн намуудын санхүүжилт, намын гишүүнчлэлийн талаар авч судалсан нь бий бөгөөд улс төрийн намын хатуу гишүүнчлэлийг дэмжих байр суурьтай байна. Э.Гэрэлт-Од (Э.Гэрэлт-од, 2015/78) намын гишүүнчлэлийг намын кадр, идэвхтэй гишүүд, оролцоотой гишүүд, дэмжигч гишүүд, албан бус дэмжигчид гэсэн 5 төрөлд хуваагаад нам гишүүнгүй байх ямар ч боломжгүй гээд сул гишүүнчлэлтэй байх нь зохистой гэсэн дүгнэлт хийжээ.

3. Намын гишүүнчлэлийн онолын зарим тайлбар:

Улс төрийн намын гишүүнчлэлийг тайлбарладаг шалгуурыг 1. Хүний эрх чөлөө, ардчилалтай, 2. Шинжлэх ухааны онолтой холбон ангилж болно.

Нэгдэх шалгуурын тухайд, Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлд заасанчлан “...нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх эрх...” (Үндсэн хууль, 1992) –ээ эдлэхийг хэлэх бөгөөд ардчиллын шалгуур улс төрийн олон ургальч үзлийн илэрхийлэл гэж ойлгож болно. Энэ тухай олонтоо ярьдаг тул бид давтахгүй, дурдаад өнгөрөв.

Хоёрдох шалгууруудын тухайд, намд элсэхийг хувь хүн, институци системн хүчин зүйл, хүний хэрэгцээ шаардлага, сэдэл, хүсэл зоригтой холбон тайлбарлахыг эрмэлздэг. Социологи, улс төр судлал зэрэг нийгмийн шинжлэх ухаанд намын гишүүнчлэлийг хэд хэдэн онолоор буюу а. Адилсалын онол (Theory of identity), б. Ээнэгшлийн онол (Attachment theory), в.Хуйвалдааны онол (theory of conspiracy) –оор тайлбарладаг.

Адилсалын онол: Идентичность (оросоор), identity (англиар) гэсэн ойлголтын дор социологи, улс төр судлалд хүн өөрийгөө аль нэг үндэстэн, ястан, улс орон, нийгмийн бүлэг, институци, бүлтэй адилсган хамаатуулах зан үйлийг ойлгодог. Адилсах гэдэг үгийн утгыг монгол хэлний толь, бичгүүдэд “адил болох, ижилсэх (Ш.Чоймаа, 2011), “адилших-юмны хэр хэмжээ, дүр төлөв улмаар адил болох” (Н.Даш, 2015) гэж ойролцоо тайлбарласан байна.

Хантингтон гуай "Бид хэн бэ?" (Huntington, 2004) номондоо АНУ-д болсон 9/11 дайралтын дараа Америкчуудын 80 гаруй хувь төрийн далбаагаараа гэрээ, машинаа, энгэрээ чимсэн гэжээ. Хүнд бэрхийг хамтдаа давна, эх орондоо итгэж, төр засгаа дэмжиж байна гэдгээ илэрхийлж, төр улстайгаа, үндэстэн, элэг нэгтэнтэйгээ адилсаж байгаа гэсэн үг л дээ.

Ф.Фукуяма “Адилсал” зохиолдоо адилсах гэдэг нь “хүнд тимос/thymos (хүний эрхэм чанараа хүндлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх хүсэл), изотомии/isothymia (бусадтай ижил хэмжээнд хүндэтгүүлэх эрмэлзлэл) болон мегатомии/megalothymia (өөрийн онцгойг нийтэд зөвшөөрүүлэх эрмэлзлэл) гэсэн сэдэл байдаг гэж үзсэн нь А. Маслау-гийн шаталсан хэрэгцээний онолтой

(Maslow's Hierarchy of needs) ойролцоо. С.Хантингтон, Ф.Фукуяма нарын үзлийн үүднээс гишүүнчлэлийг үзвэл намд элссэнээр хүнд нийгэмдээ, хүрээлэн буй орчиндоо нэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх, бусадтайгаа ижил/мөн бусдаас онцгой гэдгээ мэдрэх зэрэг хэрэгцээгээ хангаж байгаагийн илэрхийлэл аж. Ф.Фукуямагийн онолын үүднээс намын гишүүнчлэлийг тайлбарлавал, хувь хүнийхээ эрхэм чанарыг хүндлүүлж, хүлээн зөвшөөрүүлэхийн/тимос (thymos)/ тулд намд элсэхийг эрмэлзэж, Дорж элсээд байхад би юугаараа муу билээ гэж хэмээн бусдаас дутахгүй байхыг хүсэх явдал. Мөн намд элссэнээр бусдаас этгээд гаж биш бусадтай л ижил/изотомии isothymia/ байх гэсэн хүслээ биелүүлж, Дорж бид адилхан гэсэн сэтгэл ханамжийг олж авна. Монголын нөхцөлд нам ялангуяа эрх барьж буй намын гишүүн байх нь эрх мэдэл, албан тушаал, нэр нөлөө, мөнгө санхүүгийн илүү боломж хүртэх магадлал өндөр тул намын гишүүн байх хүслийг улам “шатаана”. Намын гишүүдийг давхраажлаар нь үзвээс дээр дурдсан хоёр бүлэгт ихэвчлэн жирийн гишүүд хамаарна.

Харин мегалотомии (megalothymia өөрийн онцгойг нийтэд зөвшөөрүүлэх эрмэлзлэл) бол намын элит давхраа лүгээ илүү хамааралтай бөгөөд би л удирдахгүй бол Дорж мэт “эргүүтэж дуусна” гэсэн сэдлээр хандаж, чухам надаас өөр хэн байхав гэж бусдаас гарамгай удирдагч гэдгээ намаар дамжуулан нийтэд хүлээлгэхийг зорьдог байна. Ингэхдээ олон нийтэд таалагдах популист уриаг ашиглах бөгөөд, национализм зэрэг уламжлалт үзлийг дахин амилуулж хэрэглэдэг аж. Үүнийг Ф.Фукуяма Д.Трам, В.Путин нарын жишээн дээр “..Д.Трам Америк нэгдүгээрт, Ю.Путины Орос агуу гэдэг уриа нь .. чухамдаа өмнө нь агуу байсан улс орон өрсөлдөгч сөрөг хүчнээс болж суларч доройтож байна, миний зорилго бол энэ агуу байдлыг эргэн авчрахад оршино.. гэх мэт эх оронч-националист үзлээрээ ойр ижил” (Fukuyama, 2018) хэмээн тайлбарлажээ. Өнгөрсөн социалист нийгмийн хувьд нам, эвлэлд элсэнэ, түүний гишүүн байна гэдэг нь хэн хүнд олдох хувь заяа биш бөгөөд зөвхөн мундаг сайчууд элсэж, харин удирдлага бол жир бус агуу, гарамгай хүмүүс гэсэн ойлголт нийтлэг байв.

Энэгшгийн онол: хүн, институци хооронд удаан хугацааны нийгэм-сэтгэлзүй, сэтгэл хөдлөлийн холбоо, хамаарал үүсдэг (Ainsworth, 1991) гэж үзэх бөгөөд хүн анх элссэн намдаа дасаж, түүнээсээ салж холдох хүсэлгүй, түүнийг өөрчлөх, шинэчлэх чадваргүй болдог байна. Эл холбоо хамаарал аажмаар талархал, хүндэтгэл, түгшүүр, айдас дээр суурилж, хүнийг бөх батаар намтай уяна. Бага хүүхэд ээжээ гарахад уйлдаг, ирэхэд баярладагтай, хүн олон жил амьдарч, ажилласан газраа дасч удах тусмаа өөрчилж чадахаа больдогтой ижил гэсэн үг. Маш олон хүн “олон жил энэ намтайгаа явлаа, одоо хольж солино гэж юу байхав” гэж ярихыг бид сонсож байсан нь чухамхүү энэхүү ээнэгшсэн байдалтай холбоотой бөгөөд ийм хүн аливаа сонголт хийхдээ рациональ, прагматик байдлаар бус “төрөлх нам, хар багаасаа өдий хүртэл явсан” гэх юм уу “анхны минь элссэн нам” зэргээр ханддаг аж. Яг л олон жил ханилсан ханьдаа юм уу, анхны дурлалдаа үнэнч байхтай тун ижил.

Хуйвалдааны онол: энэхүү онолын тухайд нам гэдэг нь тодорхой бүлэг, хувь хүн “нам нийлж, сэм хуйвалдаж” ард олны нийтлэг эрх ашиг гэдэг үгээр өөрсдийн явцуу ашиг сонирхолоо халхавчлан, нууц зорилгодоо хүрэх хэрэгсэл гэсэн байдлаар ханддаг. Үүний тулд тэд шинэ нам байгуулах эс бөгөөс нэгэнт байгуулагдсан намын эрх мэдлийг булаан авдаг аж. Хуйвалдааны онолын тайлбарлал бол Чехийн судлаач Михайл Клима-ийн хандлагатай тун ижил. Михайл Клима (Michal Klima) “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” номондоо (М.Клима, 2017) улс төрийн намыг хэрхэн “дээрэмдэж” болдгийг өгүүлсэн бий. Түүний үзсэнээр намыг хоёр замаар дээрэмддэг буюу:

- *Доороос нь:* хуурамч гишүүд элсүүлэх, үзэл бодол өөр ч хувийн ашиг хонжоо харсан хүмүүсийг амлалтаар татах, мөнгө өгөх,

- *Дээрээс нь:* олигарх бүлэглэлүүд улс төрд өөрийн хүнээ оруулах, удирдлагын цөөнх хуйвалдах замаар намын эрхийг авах, өөрт ашигтай хүнийг намын даргаар тавих, намын шийдвэр гаргах институци оруулж, олонхи болгох замаар хүссэн шийдвэр гаргуулдаг болох

1990 оноос хойшхи 30 гаруй жилийн хугацаанд эрх баригч томоохон намуудад өрнөсөн үйл явц чухамдаа М.Клима-гийн дурдаад байгаа “дээрмийг” бодитой болохыг харуулж байна. Заримаас дурдвал, улс төрийн 6 нам нэгдэж 2000 онд АН-ыг байгуулсан, 2010 онд МАХН-ыг МАН болгон шинэчилсэн үйл явц болон 2017 оны ерөнхийлөгчийн сонгуулийн дараах МАН-д явсан болон эдүгээ АН-д өрнөсөн тэмцэл гэх мэт жишээнүүд байна. Түүнчлэн улс төр-эдийн засгийн бүлэглэлүүд хэрхэн үгсэн хуйвалдаж болдгийг “МАНАН” харуулахын хамт өөрсдийн эрх ашгийг бусдаар хамгаалуулж үүднээс прокси (Ргоху) хуурмаг намуудыг хэрхэн байгуулж болдог зэргийг орчин цагийн монголын улс төрийн амьдрал харууллаа.

4. Намын гишүүнчлэлийн үр дагавар:

Нам байгуулах, түүнд эвлэлдэн нэгдэх, намууд чөлөөтэй үйл ажиллагаагаа явуулах гэдэг бол ардчиллын чухал шалгуур, хүний эрх, эрх чөлөөний нэг чухал хэсэг гэдэгтэй зохиогчид санал бүрэн нийлдэгээ онцлох нь чухал. Гол нь өнөөгийн Монголд намын гишүүнчлэл гэдэг нь хувь хүний эрх, эрх чөлөөний илэрхийлэл бус харин ч хүсэл зоригийнхоо эсрэг санал өгдөг, саналаа худалддаг, төрийн эрх мэдлийг хууль бусаар авахын илрэл болсон сонгуулийн хуйвалдаанд “намынхаа төлөө, намаасаа урвахгүй” гэсэн уриан дор оролцохын халхавч болсонд эмзэглэж байгаа юм.

Чухамдаа намын гишүүнчлэл нь Эрих Фроммын “Эрх чөлөөнөөс зугтахуй (Бегство от свободы)” гэдэг шиг ардчилал, шударга ёс, хуулийн засаглал тогтоход саад болж буй нэг том хүчин зүйл боллоо. Намын гишүүнчлэл нь дараах аюул дагуулж байна. Үүнд:

- *Хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчиж байна.* Бүх шатны сонгуульд хэн хаанаас нэр дэвшихыг намын удирдлага бүрэн хянаж, шийдвэрлэдэг болж, чадалтай, боловсролтой шударга нь бус, мөнгөтэй, даргад ойрхон нь нэр дэвшдэг гаж тогтолцоог бүрдүүллээ. Намаас дэвшсэн хүн таалагдсан эсэхээс үл хамааран намын гишүүний хувьд саналаа өгөхийг шууд болон шууд бусаар шаардах болж, хүний сонголтонд хөндлөнгөөс нөлөөлөхийг хуульчилж байна.
- *Төрийн эрхийг хууль бусаар авахад түлхэж байна.* Бүх шатны сонгуулийн үеэр намын гишүүдийг бусдын саналыг худалдан авах, нөлөөлөхөд түлхэх, “тавт”, “аравт”-ын систем зэрэг зохион байгуулалтанд оруулж, хүмүүсийн санал “авч ирэхийг” өөгшүүлэн дэмждэг болов.
- *Монгол улсын төрийн байгууллыг гажуудуулж байна.* Төрийн эрх барих дээд байгууллага УИХ бус харин нэр дэвшүүлж, сонгуульд оролцсон намын удирдлагын бүлэглэл болж хувирч байна. Улс орны хувь заяаг шийдэх төдийгүй ямар нэг хууль тогтоомж хэлэлцэх, батлах эсэхийг харьяа намын бүтцийн хүрээнд хэлэлцэн шийддэг болж УИХ-ын гишүүд сонгогчдын эрх ашгийг бус намын явцуу бүлэглэлийн төлөө саналаа өгдөг болж хувирч байна. Нам, түүний удирдлагыг шүүмжлэх, эсэргүүцвэл “урвагч” зэргээр цоллож, “дараа тойрог өгөхгүй” зэргээр дарамталж, бие даасан хараат бус байх нөхцлийг хөсөрдүүлсэн тэвчишгүй нөхцлийг өөгшүүлэх хэрэгсэл болов.
- *Нийгмийн ялгаварлан гадуурхалтыг албажуулж байна.* Гишүүнчлэл нь намын харьяалалаас үүдэн хүнийг хавчин гадуурхах, ажлаас халах, төрийн халамж үйлчилгээнээс хоцроох, хасах, хясах зэрэг хууль бус үйлдлийг албажуулах механизм болов. Сонгуульд ялсан эрх баригч нам нэг ёсондоо “Монголын төрийн албаны боловсон хүчний газар” болж төр, захиргааны бүх шатны томилгоог шийддэг болсноор чадахуйн/мерит зарчим бус намын харьяалал гол шалгуур болов.

- *Нийгмийн сэтгэл зүйд хортой нөлөөлж байна.* Нийгмийн шударга ёс, иргэний эрх чөлөөг хязгаарлах хэрэгсэл болж, бүтээлч, чөлөөт сэтгэлгээ, чадавхид суурилсан сэтгэлгээг бус “нам дагавал хождог” хандлагыг нийгэмд нутагшуулж байна.
- *Намын шинэ номенклатур ангийг* (Х.Гүндсамбуу, 2002) *бүрдүүлж байна.* Намын тогтолцоо өргөжсөөр намаар тэжээгддэг, намын удирдлагад үйлчилдэг нийгмийн бүхэл бүтэн “номенклатур” анги бүрдэх нөхцөл бий болов.
- *Иргэний нийгэм бүрдэхэд ноцтой саад болов.* Иргэний нийгэм, ТББ-ыг нам харьяандаа авах болсон нь гишүүнчлэлээр дамжуулан нийгэм улстөр, эдийн засаг, оюун санааг бүрэн хяналтандаа авах үйл ажиллагааг эрчимжүүллээ. Энэ байдал нь Германы ажилчны националь социалист нам дотроо “гитлерюгенд”, “Германы эмэгтэйчүүдийн холбоо” зэрэг 20 гаруй холбоо, байгууллагыг нэгтгэсэн 1930-аад он, МАХН-ын “Баатарчууд, пионер, эвлэл”-ийг нэгтгэсэн социализмын үеийг санагдуулж байна. Түүнчлэн хууль, хүчний байгууллагуудын ажилтан албан хаагчдын ажил мэргэжлийн холбоод намуудыг даган хошуурах болсон нь ардчилал, иргэний нийгмийн үзэл санааг гажуудуулан устгах нөхцөл байдлыг бүрдүүллээ. Үз: Хүснэгт 1.

Хүснэгт 1. УИХ-д суудалтай нам: гишүүнчлэл, ТББ (Дээд шүүх, 2021)

УИХ-д суудалтай нам	Гишүүдийн тоо	Харьяа ТББ
Монгол ардын нам (МАН)	161,300	<ul style="list-style-type: none"> • Монгол Ардын Намын дэргэдэх Ахмадын Холбоо • Нийгмийн Ардчилал Монголын Оюутны Холбоо • Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбоо • Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо • Стратеги Академи
Ардчилсан нам (АН)	150,000	<ul style="list-style-type: none"> • Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоо, • Ардчилсан Оюутны Холбоо • Ардчилсан Залуучуудын Холбоо • Ардчилсан Ахмадын Холбоо
Монгол ардын хувьсгалт нам (МАХН)	35000	<ul style="list-style-type: none"> • Шударга ёсны хувьсгалт Үндэсний нэгдсэн оюутны холбоо • Ардчилал Шударга ёс Монголын залуучуудын холбоо • Ардчилал Шударга ёс Монголын эмэгтэйчүүдийн холбоо
Хөдөлмөрийн үндэсний нам (ХҮН)	1024	<ul style="list-style-type: none"> • Тэгш Хүртээмжтэй Хөгжлийн Бодлогын Хүрээлэн

Төгсгөлд нь товч дүгнэн хэлэхэд:

- Нам байгуулах, түүнд эвлэлдэн нэгдэх, намууд чөлөөтэй үйл ажиллагаагаа явуулах гэдэг бол ардчиллын чухал шалгуур, хүний эрх, эрх чөлөөний нэг үндсэн хэсэг мөн.
- Гэвч Монголын өнөөгийн нөхцөл байдалд намын гишүүнчлэл нь хүний эрх, эрх чөлөөний илэрхийлэл бус харин намын цөөнх элит, шинэ номенклатур ангийн гар дахь хэрэгсэл болж хувирч байна,
- Монголын улс төрийн шинэ олигарх элитүүд болон намын номенклатур анги ч намын гишүүнчлэлийг эрх мэдэл, хөрөнгө чинээгээ нэмэгдүүлэх, явцуу ашиг сонирхлоо халхавчлахад гарамгай ашигласаар өнөөг хүрлээ.
- Улстөрийн намуудын гишүүнчлэлийн одоогийн хэлбэрийг халж, дэмжигчид бүхий намын тогтолцоог төлөвшүүлэх нь монголын улстөрийн тогтолцоог эрүүлжүүлэх нэг гол суурь болно хэмээн үзэж байна.
- Намын хатуу гишүүнчлэлийг халахгүйгээр Монголын улс төрийн тогтолцоо, түүний дотор намын төлөвшил зөв гольдролоор явахгүй гэдгийг онцлон дурдана.

Номзүй

- Ainsworth, M. D. (1991). (An ethological approach to personality development. *American Psychologist*, Vol 46, 331-341.
- Fukuyama, F. (2018). *IDENTITY, THE DEMAND FOR DIGNITY AND THE POLITICS OF RESENTMENT*. NY: Farrar, Straus and Giroux.
- Huntington, S. P. (2004). *WHO ARE WE? The Challenges To America's National Identity*. NY: Simon & Schuster.
- Statista. (2021 оны 04 15). *Statista.com*. <https://www.statista.com>
- Б.Эрдэнэдалай. (2021/3). Монгол дахь улс төрийн намын төлөвшлийн асуудалд. *Төрийн байгуулал судлал*, 6-15.
- Д. Бадамдаш болон бусад (2020). *Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт*. Улаанбаатар: Конрад Аденаур сан.
- Дээд шүүх. (2021 оны 04 17). *Улсын дээд шүүх*. www.supremecourt.mn
- М.Клима. (2017). *Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу (Орчуулга)*. УБ: Сэлэнгэпресс ХХК.
- Монгол улсын Үндсэн хууль. (2022 оны 12 01). *Эрх зүйн нэгдсэн систем*. <https://legalinfo.mn-ээс> Гаргасан
- Н.Даш. (2015). *Монгол хэлний их үгийн толь*. УБ: Монсудар.
- О.Мөнхбат. (2019). Улстөрийн нам авлигын системын "хөдөлгөгч хүч" болсон нь. *Jargal Defacto gazetto*, 1-5.
- С.Мөнхбат. (2009). *Монгол дахь улстөрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөвшлийн зарим асуудал*. Улаанбаатар: МУИС.
- Төрийн албаны тухай хууль. (2022 оны 11 24). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. <https://legalinfo.mn>
- УИХ. (2014). *Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь*. Улаанбаатар: УИХ-ын АБГББХ.
- Үндсэн хууль. (1992 оны 01 01). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан*. <https://www.legalinfo.mn>
- ҮСХ. (2021 оны 04 20). Хүн амын тоо. Улаанбаатар, Монгол улс.
- Ф.Фукуяма. (2019). *Идентитичность. Стремление к признанию и политика неприятия*. Москва: Альпина паблишер.
- Х.Гүндсамбуу. (2002). *Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага*. УБ: Социологичдын "Зотол" клуб.
- Ц.Мөнхцэцэг. (2018). *Цахим популизм буюу сонгууль дахь социал сүлжээний нөлөө*. Улаанбаатар: МУБИС.
- Ш.Чоймаа, М. (2011). *Монгол хэлний хадмал толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Э.Гэрэлт-од. (2015/78). Монголын улс төрийн намуудын гишүүнчлэл, хандлага, шийдэл. *Шинэ толь*.